



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх “COVID-19” цар тахлын нөлөө /2021 оны III улирал/

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: (+976) 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	4
БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ	7
АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭН	7
БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	8
АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА	9
АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД	11
ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА	13
БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ	16
ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА	16
ДААТГУУЛАГЧ	16
ШИМТГЭЛИЙН ОРЛОГО	17
АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ	19
БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн.....	4
ХҮСНЭГТ 1.2 АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 2-р улирал	5
ХҮСНЭГТ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, эхэнд.....	7
ХҮСНЭГТ 2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, сарын эхэнд.....	8
ХҮСНЭГТ 2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, өсөн нэмэгдэхээр.....	9
ХҮСНЭГТ 2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн	10
ХҮСНЭГТ 2.5 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн	10
ХҮСНЭГТ 2.6 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр.....	11
ХҮСНЭГТ 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр	16
ХҮСНЭГТ 3.2 ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр	16
ХҮСНЭГТ 3.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр.....	17
ХҮСНЭГТ 3.4 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр.....	17
ХҮСНЭГТ 3.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг.....	18
ХҮСНЭГТ 3.7 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг	19
ХҮСНЭГТ 3.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр.....	19
ХҮСНЭГТ 3.9 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн, сараар	4
ЗУРАГ 1.2 ХӨДӨЛМӨРИЙН ОРОЛЦОО БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, хувь, улирлаар	6
ЗУРАГ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, өмнөх оны мөн үетэй харьцуулсан	7
ЗУРАГ 2.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, мянган хүн, 9-р сарын байдлаар	8
ЗУРАГ 2.3 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, мянган хүн, 9-р сарын байдлаар	9
ЗУРАГ 2.4 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД	11
ЗУРАГ 2.5 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үеэс, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн	12
ЗУРАГ 2.6 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үеэс, ажил мэргэжлийн ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн	12
ЗУРАГ 2.7 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ХУВЬ, сараар	13
ЗУРАГ 2.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГЫГ ЭРЭЛТЭЭР ХАНГАСАН ХУВЬ, сараар	13
ЗУРАГ 2.9 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, , өсөн нэмэгдсэн дүн, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, хувиар	14
ЗУРАГ 2.10 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, өссөн нэмэгдсэн дүн, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар	15
ЗУРАГ 3.3 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг	18
ЗУРАГ 3.4 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар	20

БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үндэсний статистикийн хорооноос 2021 оны 3-р улирлын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн мэдээг зарлаагүй байгаа тул энэ бүлэгт хөдөлмөр эрхлэлтийн 2-р улирлын мэдээг ашиглалаа.

2021 оны 2-р улирлын байдлаар хөдөлмөрийн насны хүн амын 56.8 хувь нь ажиллах хүч, 43.2 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. 2021 оны 2-р улиралд ажиллах хүч 1.2 сая болж өмнөх оны мөн үеэс 61.9 мянга буюу 4.9 хувиар буурсан бол өмнөх улирлаас 50.9 мянга буюу 4.4 хувиар өссөн байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам 916.9 мянга болж өмнөх оны мөн үеэс 62.4 мянга буюу 7.3 хувиар өссөн бол өмнөх улирлаас 32.7 мянга буюу 3.4 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн

Үзүүлэлт	2020-II	2021-I	2021-II	Өсөлт/Бууралт /өмнөх оны мөн үеэс/	
				Тоо	Хувь
Ажиллах хүч	1 268.9	1 156.1	1 206.9	-61.9	-4.9
Ажиллагчид	1 185.2	1 054.9	1 105.7	-79.5	-6.7
Ажилгүй хүн	84.7	101.2	101.3	17.6	21.0
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	855.5	949.7	916.9	62.4	7.3
Боломжит ажиллах хүч	74.7	108.8	71.8	-2.0	-2.7
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	781.7	840.9	845.1	64.4	8.2

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2021 оны 2-р улирлын байдлаар ажиллагчид 1 105.7 мянга болж өмнөх оны мөн үеэс 79.5 мянга буюу 6.7 хувиар буурсан бол өмнөх улирлаас 50.8 мянга буюу 4.8 хувиар өссөн байна. Харин ажилгүй иргэд 101.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 17.6 мянга буюу 21.0 хувиар, өмнөх улирлаас 0.1 мянгаар өссөн байна.

ЗУРАГ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Доорх хүснэгтэд ажиллагчдын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харууллаа. 2021 оны 2-р улирлын байдлаар ажиллагчид өмнөх оны мөн үеэс 79.4 мянгаар буурсны 23.0 мянга (29.0 хувь) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин,

мотоциклын засвар, үйлчилгээний салбар, 24.7 мянга (31.2 хувь) нь хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбар, 17.3 мянга (21.8 хувь) нь боловсролын салбар, 14.7 мянга (18.5 хувь) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар, 12.9 мянга (16.3 хувь) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар байна. Харин хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажиллагчид өмнөх оны мөн үеэс 21.4 мянгаар өссөн дүнтэй байна.

ХҮСНЭГТ 1.2 АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 2-р улирал

Салбар	Өсөлт/Бууралт	
	Өмнөх улирал	Өмнөх он
Бүгд	50 824	- 79 489
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	- 12 423	21 374
Уул уурхай, олборлолт	8 446	2 305
Боловсруулах үйлдвэрлэл	8 473	- 835
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2 338	6 950
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	- 4 562	- 1 570
Барилга	24 975	- 6 510
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	13 333	- 23 038
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	- 370	- 14 685
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	5 339	11 303
Мэдээлэл, холбоо	6 892	- 2 500
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	818	- 3 971
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	670	- 1 994
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	- 3 455	- 4 292
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	- 6 110	- 1 630
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	6 857	1 110
Боловсрол	6 898	- 17 345
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	- 3 555	- 24 771
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	190	34
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	- 421	- 12 924
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	- 1 821	- 2 725
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	- 1 688	- 3 775

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо


Ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны 2-р улирлын байдлаар 56.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр буурсан бол өмнөх улирлаас 1.9 пунктээр өссөн байна. Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2021 оны 2-р улирлын байдлаар 52.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол өмнөх улирлаас 2.0 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 1.2 ХӨДӨЛМӨРИЙН ОРОЛЦОО БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, хувь, улирлаар



Ажилгүйдлийн түвшин 2021 оны 2-р улирлын байдлаар 8.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр, өмнөх улирлаас 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол ажилгүйдэл 1.8 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 1.3 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН НИЙЛМЭЛ ТҮВШИН, хувь, улирлаар



БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ

АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭН

Ажил хайж байгаа иргэдийн хөдөлгөөний тоо мэдээнээс харахад 2021 оны 9-р сарын эхэнд 22.6 мянган иргэн ажил хайж байсан бол тайлант хугацаанд 9.4 мянгаар нэмэгдэж, 10.2 мянгаар хасагдаж, сарын эцэст 21.8 мянган иргэн болж, цэвэр дүнгээр 0.8 мянгаар буурсан байна.


ХҮСНЭГТ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, эхэнд

Он сар	Ажил хайгч /сарын эхэнд/	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард хасагдсан	Ажилд зуучлагдсан	Ажил хайгч /сарын эцэст/
I	29 952	6 446	10 364	1 061	26 034
II	26 034	5 408	8 112	584	23 330
III	23 330	8 573	6 798	1 910	25 105
IV	25 105	5 730	5 555	1 117	25 280
V	25 280	7 956	6 890	2 587	26 346
VI	26 346	11 326	10 681	4 646	26 991
VII	26 991	5 027	9 449	1 543	22 569
VIII	22 569	8 006	7 934	2 310	22 641
IX	22 641	9 405	10 242	2 367	21 804

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайж байгаа иргэдийн тоо 2021 оны 9-р сарын эцэст 21.8 мянга болж өмнөх улирлын эцсээс 5.2 мянга буюу 19.2 хувь, оны мөн үеэс 5.7 мянга буюу 20.7 хувиар буурсан байна.

ЗУРАГ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, өмнөх оны мөн үетэй харьцуулсан




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Тухайн сард нэмэгдсэн болон хасагдсан иргэдийг авч үзвэл 9-р сард ажил хайж байгаа иргэд 9.4 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.1 мянга буюу 28.0 хувиар өссөн байна. Мөн тухайн сард ажил хайж байгаа иргэд 10.2 мянгаар хасагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.4 мянга буюу 30.9 хувиар өссөн байна. 2020 оны 9-р сард хасагдсан иргэдийн 29.3 хувь нь ажилд зуучлагдаж байсан бол 2021 оны 9-р сард 23.1 хувь нь ажилд зуучлагдаж 6.2 пунктээр буурсан байна. 9-р сарын эцсийн байдлаар ажил хайж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс буурсан боловч тухайн сар доторх хөдөлгөөн өмнөх оны

мөн үеэс өссөн байгаа нь ажил хайж байгаа иргэдийн хөдөлгөөн тогтворгүй байгааг харуулж байна.

ЗУРАГ 2.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, мянган хүн, 9-р сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

2021 оны 9-р сарын эхэнд 15.3 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байсан бол тайлант хугацаанд 6.5 мянган хүнээр нэмэгдэж, 6.8 мянган хүнээр хасагдаж, цэвэр дүнгээр 263 хүнээр өссөн байна. 2021 оны 9-р сарын эцэст 15.0 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 мянга буюу 15.6 хувиар буурчээ. Тайлант хугацаанд хасагдсан бүртгэлтэй ажилгүй иргэдээс 22.3 хувь нь ажилд зуучлагдсан байна.


ХҮСНЭГТ 2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сарын эцэст, сарын эхэнд

Сар	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эхэнд/	Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	Тайлант хугацаанд хасагдсан иргэн	Ажилд зуучлагдан орсон иргэн	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/
I	18 103	4 515	6 146	711	16 472
II	16 472	3 583	4 593	307	15 462
III	15 462	5 676	4 363	1 063	16 775
IV	16 775	3 640	3 726	643	16 689
V	16 689	5 390	4 652	1 618	17 427
VI	17 427	7 556	7 333	3 071	17 650
VII	17 650	3 458	5 876	1 011	15 232
VIII	15 232	5 271	5 184	1 263	15 319
IX	15 319	6 520	6 786	1 515	15 053

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тухайн сард нэмэгдсэн болон хасагдсан дүнг авч үзвэл, 2021 оны 9-р сард бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 6.5 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.8 мянга буюу 39.3 хувиар өссөн байна. Мөн тухайн сард ажил хайж байгаа иргэд 6.8 мянгаар хасагдаж, өмнөх оны мөн үеэс 1.6 мянга буюу 32.0 хувиар өссөн. Тухайн сард хасагдсан бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3.1 мянган буюу 22.3 хувь нь ажилд зуучлагдсан. 2021 оны 1-р сард бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 18.1 мянга байсан бол 6-р сарын эцэст 17.6 мянга болж 0.4 мянга буюу 2.5 хувиар буурсан дүнтэй байна.

ЗУРАГ 2.3 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, мянган хүн, 9-р сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА

2021 оны эхний гурван улирлын байдлаар нийт 32.7 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 9.8 мянга буюу 23.0 хувиар буурсан байна. 2021 оны 3-р улиралд 12.3 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.1 мянга буюу 14.5 хувиар буурсан.

ХҮСНЭГТ 2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
I	2 795	2 795	1 334	1 334	-1 461	-52.3
II	5 098	2 303	2 610	1 276	-2 488	-48.8
III	7 595	2 497	6 413	3 803	-1 182	-15.6
IV	12 055	4 460	9 007	2 594	-3 048	-25.3
V	21 358	9 303	13 538	4 531	-7 820	-36.6
VI	28 036	6 678	20 352	6 814	-7 684	-27.4
VII	31 216	3 180	25 356	5 004	-5 860	-18.8
VIII	39 115	7 899	28 518	3 162	-10 597	-27.1
IX	42 433	3 318	32 656	4 138	-9 777	-23.0

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний гурван улиралд ирсэн нийт ажлын байрны захиалгын 30.2 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбараас, 17.1 хувь нь барилгын салбараас, 7.7 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар, 7.0 хувь нь уул уурхайн, олборлолтын салбараас, 6.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ирсэн байна.

Ажлын байрны захиалгыг салбар бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, боловсролын салбар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарууд өмнөх оны мөн үеэс буурсан байгаа бол хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбар, уул уурхай, олборлолтын салбар, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудын ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

2021 оны эхний гурван улиралд нийт ирсэн ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 9.8 мянгаар буурсны 88.6 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, 18.6 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ЭЗҮА-ны салбарын ангилал, өсөн нэмэгдсэн дүн

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
Бүгд	42 433	32 656	-9 777	-23.0
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2 978	1 905	-1 073	-36.0
Уул уурхай, олборлолт	1 235	2 273	1 038	84.0
Боловсруулах үйлдвэрлэл	1 886	2 008	122	6.5
Барилга	5 863	5 576	-287	-4.9
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	1 230	1 627	397	32.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	646	616	-30	-4.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	836	796	-40	-4.8
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 678	1 564	-114	-6.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 761	944	-1817	-65.8
Боловсрол	1 746	1 406	-340	-19.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1 101	2 503	1402	127.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	18 510	9 850	-8660	-46.8
Бусад	1 963	1 588	-375	-19.1

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний гурван улиралд нийт ирсэн ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 6.4 мянга (19.7 хувь) нь мэргэжилтэн, 6.1 мянга (18.8 хувь) нь энгийн ажил, мэргэжил, 5.5 мянга (16.7 хувь) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 3.9 мянга (12.0 хувь) нь худалдаа, үйлчилгээний ажилтны захиалга байна.

Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл худалдаа, үйлчилгээний ажилтан 44.4 хувь, энгийн ажил мэргэжил 31.3 хувь, ХАА, ой, загас агнуурын ажилтан 37.6 хувиар буурсан буюу хамгийн их бууралттай байна.

ХҮСНЭГТ 2.5 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангилал, өсөн нэмэгдсэн дүн

Ажил мэргэжлийн ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
Бүгд	42 433	32 656	-9 777	-23.0
Менежер	1 600	1 742	142	8.9
Мэргэжилтэн	7 402	6 440	-962	-13.0
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	3 091	2 654	-437	-14.1
Контор, үйлчилгээний ажилтан	2 311	1 953	-358	-15.5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	7 061	3 927	-3134	-44.4
ХАА, ой, загас агнуурын ажилтан	2 125	1 325	-800	-37.6
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	6 912	5 458	-1454	-21.0
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	2 364	2 576	212	9.0
Энгийн ажил, мэргэжил	8 958	6 154	-2 804	-31.3
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	609	427	-182	-29.9

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД

2021 оны эхний гурван улирлын байдлаар нийт ажилд зуучлагдсан иргэдийн тоо 17.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 4.0 мянга буюу 18.6 хувиар буурсан байна. Харин 9-р сард 2.4 мянган иргэн ажилд зуучлагдаж, өмнөх оны мөн үеэс 0.1 мянгаар өссөн байна.


ХҮСНЭГТ 2.6 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, III улирлын байдлаар

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	1 398	1 398	572	572	- 826	-59.1
II	2 695	1 297	1 156	584	-1 539	-57.1
III	4 489	1 794	3 066	1 910	-1 423	-31.7
IV	7 266	2 777	4 183	1 117	-3 083	-42.4
V	11 171	3 905	6 770	2 587	-4 401	-39.4
VI	15 250	4 079	11 416	4 646	-3 834	-25.1
VII	17 458	2 208	12 959	1 543	-4 499	-25.8
VIII	19 381	1 923	15 269	2 310	-4 112	-21.2
IX	21 672	2 291	17 636	2 367	-4 036	-18.6

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Тухайн сар бүрд ажилд зуучлагдсан иргэдийн тоог доорх зурагт үзүүлэв. 3-р улиралд ажилд зуучлагдсан иргэдийн тоо өмнөх улирлаас харьцангуй бага байдаг нь харагдаж байна. 8-р сар болон 9-р сард ажилд зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс бага зэрэг их боловч тухайн саруудад хасагдсан ажил хайж байгаа иргэдэд эзлэх хувь нь буурсан байна.

ЗУРАГ 2.4 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 9-р сар хүртэл нийт ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 28.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 12.5 хувь нь барилгын салбарт, 8.8 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт, 7.9 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 7.0 хувь нь уул уурхайн, олборлолтын салбарт зуучлагдсан байна.

ХАА, ойн аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс буурсан байгаа бол уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, хүний эрүүл мэнд

ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

Ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 4.0 мянгаар буурсан бөгөөд 50.9 хувийг үйлчилгээний бусад, 22.4 хувийг ХАА, ойн аж ахуй, 18.3 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар бүрдүүлж байна.

ЗУРАГ 2.5 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үеэс, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 9-р сар хүртэл нийт ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл 21.7 хувь нь мэргэжилтэн, 18.9 хувь нь энгийн ажил, мэргэжил, 16.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан байна.

Менежер болон зэвсэгт хүчний ажил, мэргэжил чиглэлээр ажилд зуучлагдсан иргэд оны мөн үеэс бага зэрэг өссөн бөгөөд бусад ажил мэргэжлээр ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс буурсан байгаа нь доорх зурагт харагдаж байна.

Ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 4.0 мянгаар буурсны 32.2 хувийг энгийн ажил, мэргэжил, 19.1 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 14.8 хувийг контор, үйлчилгээний ажилтан, 14.7 хувийг худалдаа, үйлчилгээний ажилтан бүрдүүлж байна.

ЗУРАГ 2.6 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үеэс, ажил мэргэжлийн ангиллаар, өсөн нэмэгдсэн дүн




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА

2020 оны 9-р сарын эхэнд 28.0 мянган иргэн ажил хайж байсны 2.3 мянга буюу 8.2 хувь нь ажилд зуучлагдсан бол 2021 оны 9-р сарын эхэнд 22.6 мянган иргэн ажил хайж байсны 2.4 мянга буюу 10.5 хувь нь ажилд зуучлагдсан байна. Ажилд зуучлагдсан иргэн өмнөх улирлын төгсгөлөөс 2.2 мянгаар буурсан.


ЗУРАГ 2.7 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ХУВЬ, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний гурван улиралд нийт 32.7 мянган ажлын байрны захиалга ирсний 18.1 мянга буюу 55.5 хувийг эрэлтээр хангаад байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 пунктээр илүү байна. Сар бүрд ирсэн ажлын байрны захиалгыг эрэлтээр хангасан хувийг доорх зурагт үзүүлэв.

ЗУРАГ 2.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГЫГ ЭРЭЛТЭЭР ХАНГАСАН ХУВЬ, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний гурван улиралд нийт ирсэн ажлын байрны захиалгыг эрэлтээр хангасан хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын

салбарын 77.5 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 61.8 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбарын 61.0 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын 51.2 хувийг эрэлтээр хангасан нь өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Харин хөдөө аж ахуй, ой, загас барилт, ан агнуурын салбарын 72.7 хувь, боловсролын салбарын 66.1 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын 72.6 хувь, уул уурхай, олборлолт салбарын 54.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 48.7 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын 40.3 хувийг эрэлтээр хангасан боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрэлтийг хангасан хувь нь буурсан байна.


ЗУРАГ 2.9 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, өсөн нэмэгдсэн дүн, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны эрэлтийн захиалгыг эрэлтээр хангасан хувийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл, зэвсэгт хүчний ажил, мэргэжил чиглэлээр ирсэн захиалгын 47.1 хувийг, менежер чиглэлээр ирсэн захиалгын 59.3 хувийг, мэргэжилтэн чиглэлээр ирсэн захиалгын 59.3 хувийг, худалдаа, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 48.7 хувийг, ХАА, ой, загас агнуурын ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 84.1 хувийг, энгийн ажил, мэргэжил чиглэлээр ирсэн захиалгын 54.2 хувийг эрэлтээр хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Харин контор, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 43.0 хувийг, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч чиглэлээр ирсэн захиалгын 47.8 хувийг эрэлтээр хангасан боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрэлтээр хангасан хувь буурсан байна.

ЗУРАГ 2.10 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, өссөн нэмэгдсэн дүн, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллага, даатгуулагч болон шимтгэлийн орлого, ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэд гэх мэт хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг энэ бүлэгт авч үзнэ.

ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА

2021 оны 3-р улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 50.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.8 мянга буюу 5.9 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 90.9 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.1 хувь нь төсвийн байгууллага байна.

ХҮСНЭГТ 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	9 692	9 692	2 815	2 815	- 6 877	-70.96
II	39 687	29 995	38 631	35 816	- 1 056	-2.66
III	42 862	3 175	46 242	7 611	3 380	7.89
IV	44 636	1 774	47 970	1 728	3 334	7.47
V	46 206	1 570	48 458	488	2 252	4.87
VI	46 762	556	48 738	280	1 976	4.23
VII	47 129	367	49 558	820	2 429	5.15
VIII	47 412	283	50 059	501	2 647	5.58
IX	47 818	406	50 625	566	2 807	5.87

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

ДААТГУУЛАГЧ

2021 оны 3-р улиралд 99.6 мянган иргэн нэмж нийгмийн даатгалд хамрагдаж эхний гурван улирлын байдлаар нийт 1.1 сая иргэн нийгмийн даатгалд даатгуулаад байна. Үүний 60.5 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллагын даатгуулагчид, 25.5 хувь нь төсөвт байгууллагын даатгуулагчид, 13.9 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс 10.7 мянга буюу 1.0 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.2 ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	Нийт даатгуулагчид	Албан журмын даатгуулагч	Хувийн ААНБ		Сайн дурын
			Төсөвт байгууллага	Төсөвт байгууллага	
I	91 521	50 617	24 636	25 981	40 904
II	738 140	665 503	452 416	213 087	72 637
III	845 802	744 846	503 902	240 944	100 956
IV	900 570	777 449	532 103	245 346	123 121
V	927 880	799 274	549 683	249 591	128 606
VI	962 387	826 246	572 200	254 046	136 141
VII	997 126	857 236	599 076	258 160	139 890
VIII	1 023 963	880 655	618 681	261 974	143 308
IX	1 062 030	914 203	643 016	271 187	147 827

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагчдын тоо 914.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 35.8 мянга буюу 4.1 хувиар өссөн байна. Албан журмын даатгуулагчдын 70.3 хувь нь хувийн аж ахуй

нэгж байгууллага, 29.7 хувийг төсөвт байгууллагын даатгуулагчид байна. Хувийн аж ахуй нэгж байгууллага өмнөх оны мөн үеэс 29.8 мянга буюу 4.9 хувиар, төсөвт байгууллага 6.0 мянга буюу 2.2 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Хувийн ААН	Төрийн байгууллага
I	77 979	64 411	24 636	25 981	- 53 343	-38430
II	455 547	226 097	452 416	213 087	- 3 131	-13010
III	486 890	237 011	503 902	240 944	17 012	3933
IV	508 458	239 239	532 103	245 346	23 645	6107
V	535 898	244 619	549 683	249 591	13 785	4972
VI	556 274	248 794	572 200	254 046	15 926	5252
VII	574 476	252 080	599 076	258 160	24 600	6080
VIII	591 081	258 828	618 681	261 974	27 600	3146
IX	613 189	265 228	643 016	271 187	29 827	5959

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2021 оны 3-р улиралд 11.7 мянган иргэн сайн дурын нийгмийн даатгалд нэмэгдэж хамрагдсан бөгөөд эхний гурван улирлын байдлаар нийт 147.8 мянган иргэн сайн дурын даатгалд даатгуулсан байна. Сайн дурын даатгуулагчдын 27.8 хувь нь малчид, 12.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна. Сайн дурын даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс 25.1 мянга буюу 14.5 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 3.4 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он			2021 он		
	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо
I	41 789	10 549	6 142	40 904	4 993	4 050
II	81 302	18 993	12 273	72 637	10 488	6 295
III	108 042	25 962	16 149	100 956	18 630	8 218
IV	120 939	31 050	17 398	123 121	24 860	9 259
V	144 324	40 969	20 084	128 606	25 453	9 365
VI	156 624	46 028	21 002	136 141	25 979	9 752
VII	161 416	47 483	21 077	139 890	26 202	9 690
VIII	163 968	47 789	21 269	143 308	26 214	9 629
IX	172 892	47 992	21 371	147 827	26 219	9 570

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Малчид: Сайн дураар даатгуулсан малчид 2021 оны эхний гурван улирлын байдлаар нийт 26.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 21.8 мянга буюу 45.4 хувиар буурсан байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч: Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2021 оны эхний гурван улирлын байдлаар нийт 9.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 11.8 мянга буюу 55.2 хувиар буурсан байна.

ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

2021 оны 3-р улиралд нийгмийн даатгалын санд 494.3 тэрбум төгрөг нэмэгдэж, эхний гурван улирлын байдлаар нийт 1,436.4 тэрбум төгрөгийн орлогыг татан төвлөрүүлээд

байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 360.1 тэрбум төгрөг буюу 33.5 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 3.5 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
I	131.8	131.8	121.2	121.2	-10.6	-8.1
II	271.4	139.6	264.2	143.1	-7.1	-2.6
III	420.5	149.1	437.9	173.7	17.4	4.1
IV	520.2	99.7	585.0	147.1	64.8	12.5
V	618.1	97.9	745.2	160.2	127.1	20.6
VI	721.7	103.5	942.1	196.9	220.5	30.5
VII	860.8	139.1	1093.2	151.1	232.5	27.0
VIII	966.4	105.6	1258.3	165.1	291.9	30.2
IX	1076.4	110.0	1436.4	178.1	360.1	33.5

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тухайн сард бүрд нэмэгдсэн шимтгэлийн орлогыг өмнөх оны мөн үетэй нь харьцуулж доор үзүүлэв. 2021 оны 1-р сараас бусад саруудад нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

ЗУРАГ 3.1 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын 87.0 хувийг бүрдүүлж байна. 2021 оны 3-р улиралд 427.4 тэрбум төгрөг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлж, эхний гурван улирлын байдлаар нийт 1,250.0 тэрбум төгрөг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн байна. Нийт төвлөрүүлсэн тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 405.8 тэрбум төгрөг буюу 48.1 хувиар өссөн байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын 6.2 хувийг бүрдүүлж байна. 2021 оны 3-р улиралд 31.7 тэрбум төгрөг тэтгэмжийн даатгалын санд төвлөрүүлсэн бол эхний гурван улирлын байдлаар нийт 89.1 тэрбум төгрөгийг тэтгэмжийн даатгалын санд төвлөрүүлсэн байна. Нийт төвлөрүүлсэн тэтгэмжийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 2.0 тэрбум төгрөг буюу 2.2 хувиар буурсан байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлого нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын 5.2 хувийг бүрдүүлж байна. 2021 оны

3-р улиралд 24.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, эхний гурван улирлын байдлаар нийт 71.1 тэрбум төгрөгийн орлогыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төвлөрүүлсэн байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 45.3 тэрбум төгрөг буюу 38.0 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нь нийгмийн даатгалын сангийн орлогын 1.6 хувийг бүрдүүлж байна. 2021 оны 3-р улиралд 10.6 тэрбум төгрөгийн орлого ажилгүйдлийн даатгалын санд төвлөрүүлж, эхний гурван улирлын байдлаар нийт 23.3 тэрбум төгрөг ажилгүйдлийн даатгалын санд төвлөрсөн байна. Нийт ажилгүйдлийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөг буюу 7.4 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг

Сар	2020 он				2021 он			
	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл
I	104.1	12.8	12.3	2.6	131.8	10.6	10.1	2.2
II	213.9	26.4	25.4	5.6	271.4	23.2	21.9	4.8
III	331.8	40.8	39.2	8.8	420.5	25.3	22.2	4.9
IV	410.6	50.4	48.4	10.9	520.2	29.8	26.1	5.6
V	488.6	59.7	57.0	12.9	618.1	37.4	35.9	7.0
VI	568.1	70.3	67.8	15.4	721.7	57.4	49.4	12.7
VII	653.9	80.8	105.9	20.1	860.8	71.9	59.0	21.4
VIII	756.8	81.8	108.0	19.7	966.4	87.1	72.0	22.7
IX	844.1	91.1	119.4	21.7	1076.4	89.1	74.1	23.3

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ

2021 оны эхний гурван улирлын байдлаар нийт 19.2 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмж хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 3.5 мянган иргэн буюу 22.0 хувиар өссөн байна. 2020 оны 3-р улиралд сар дунджаар 1.7 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байсан бол 2021 оны 3-р улиралд сард дунджаар 2.3 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байна. 2021 оны 9-р сард 2.9 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа бөгөөд 2-р улирлын төгсгөл буюу 6-р сараас 890 иргэн буюу 45.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 807 буюу 39.3 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.7 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
I	2 076	2 076	2 887	2 887	811	39.1
II	3 662	1 586	4 624	1 737	962	26.3
III	5 268	1 606	6 938	2 314	1 670	31.7
IV	7 498	2 230	8 323	1 385	825	11.0
V	9 376	1 878	10 246	1 923	870	9.3
VI	10 622	1 246	12 216	1 970	1 594	15.0
VII	12 075	1 453	14 123	1 907	2 048	17.0
VIII	13 735	1 660	16 403	2 280	2 668	19.4
IX	15 788	2 053	19 263	2 860	3 475	22.0

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2021 оны 3-р улиралд 12.7 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд эхний гурван улирлын байдлаар нийт 39.4 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар өссөн байна. 2021 оны 9-р сард ажилгүйдлийн тэтгэмжид 5.0 тэрбум төгрөг зарцуулсан буюу бусад саруудаас хамгийн өндөр байна.


ХҮСНЭГТ 3.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	2020-2021		2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
		Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн				
I	4 949	4 949	4 337	4 337	- 612	-14.1	
II	8 750	3 802	8 925	4 589	175	2.0	
III	12 897	4 147	13 556	4 631	659	4.9	
IV	17 040	4 143	18 203	4 647	1 162	6.4	
V	21 629	4 589	22 745	4 542	1 115	4.9	
VI	26 055	4 426	26 632	3 887	576	2.2	
VII	30 115	4 060	30 199	3 567	84	0.3	
VIII	33 775	3 660	34 365	4 166	590	1.7	
IX	37 657	3 882	39 367	5 002	1 710	4.3	

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нэг хүнд зарцуулсан дундаж ажилгүйдлийн тэтгэмжийн зардлыг сар бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл сүүлийн 4 сард өмнөх оны мөн үеэс буурсан дүнтэй байгаач энэ нь тухайн саруудад ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байгаа учир нэг хүнд ногдох дундаж зардал буурсан харагдаж байна.

ЗУРАГ 3.2 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

2021 оны 2-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажиллах хүч 61.9 мянга буюу 4.9 хувиар буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 62.4 буюу 7.3 хувиар өсөж, хөдөлмөрийн насны хүн амын оролцооны түвшин 56.8 болж 3.0 пунктээр буурсан байна. Харин 2021 оны 1-р улирал буюу өмнөх улиралтай харьцуулж үзвэл ажиллах хүч 50.9 мянга буюу 4.4 хувиар өсөж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 32.7 мянга буюу 3.4 хувиар буурч, ажиллах хүчний оролцооны түвшин 56.8 хувь болж 1.9 пунктээр өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан дүнтэй байгаа боловч өмнөх улиралтай харьцуулахад өссөн дүнтэй байгаа нь цар тахалтай холбоотой хөл хорио суларсан болон аж ахуй нэгж байгууллага, бизнесүүд үйл ажиллагаа явуулж хөдөлмөр эрхлэх боломжтой болсонтой холбоотой байх.

Ажил хайж байгаа иргэдийн тоо 9-р сарын эцсийн байдлаар 21.8 мянга болж өмнөх улирлын төгсгөлөөс 19.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 20.7 хувиар буурсан боловч тухайн сард ажил хайхаар нэмэгдсэн иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 28.0 хувиар, тухайн сард хасагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 30.9 хувиар өссөн байгаа нь иргэдийн ажил хайж сонирхол болон ажил хайх үйл явц тогтворгүй байгааг харуулж байна. Мөн тухайн сард хасагдсан иргэд өссөн боловч хасагдсан иргэдийн ажилд зуучлагдсан хувь өмнөх оны мөн үеэс 6.2 пунктээр буурсан байна.

2021 оны 3-р улирлын байдлаар албан журмын даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 35.8 мянга буюу 4.1 хувиар өссөн бол сайн дурын даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 25.1 мянга буюу 14.5 хувиар буурсан байгаа нь Ковид-19 цар тахал албан салбараас илүү албан бус салбарт нөлөөлж байгаа нь харагдаж байна.

2021 оны 3-р улирлын төгсгөл буюу 9-р сард ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн тоо 2.9 мянга болж 2-р улирлын төгсгөлөөс 0.9 мянга буюу 45.2 хувиар өссөн байна. Мөн нийт ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.